

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

**АВТО ЗАМЫН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Авто замын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6 дахь хэсгийн, 33 дугаар зүйлийн 33.1, 33.2, 33.3 дахь хэсгийн “Зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

**АВТОТЭЭВРИЙН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Автотээврийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн гарчгийн “Тусгай зөвшөөрөл” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдэл” гэж, мөн зүйлийн 15.1 дэх хэсгийн “Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 5.3, 5.5, 5.12-т заасан тусгай зөвшөөрөлтэй” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 4.6-д заасныг энгийн зөвшөөрөлтэйгөөр” гэж, 8.3 дугаар зүйлийн “4.1, 4.2-т заасныг” гэснийг “мэдэгдэл хүлээн авсан” гэж, 15.2 дахь хэсгийн “харилцааг Зөвшөөрлийн” гэснийг “, мэдэгдлээр эрхлэх үйл ажиллагааг Зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж, 15.5, 15.6 дахь хэсгийн “Тусгай зөвшөөрөл” гэснийг “Зөвшөөрөл” гэж, 15.9 дэх хэсгийн “эрхлэх тусгай зөвшөөрлийг” гэснийг “мэдэгдлээр эрхлэхэд” гэж, 15.10 дахь хэсгийн “эрхлэх тусгай зөвшөөрлийг” гэснийг “үйлчилгээг мэдэгдлээр эрхлэхэд” тус тус гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Автотээврийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.5, 15.6, 15.7 дахь хэсгийн, мөн зүйлийн 15.5.1 дэх заалтын “тусгай” гэснийг хассугай.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

АГААРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Агаарын тухай хуулийн 18 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай дараах хэсэг нэмсүгэй:

1/18 дугаар зүйлийн 18.5, 18.6 дахь хэсэг:

“18.5.Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуулийн 3.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу агаарын бохирдлын томоохон суурин эх үүсвэрийг мэдэгдлээр ашиглахтай холбоотой мэдэгдлийг маягтыг тухайн сум, дүүргийн Засаг дарга батална.

18.6.Энэ зүйлийн 18.1-д заасан мэдэгдлээр эрхлэх үйл ажиллагааг цахимаар явуулна.”

2/25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсэг:

“25.2.Энэ хуулийн 25.1-д заасан мэдэгдлээр эрхлэх үйл ажиллагааг цахимаар явуулна.”

2 дугаар зүйл. Агаарын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийн “Генетик нөөц” гэсний өмнө “Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1.8-д заасан” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Агаарын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“18.1.Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуулийн 8.3 дугаар зүйлийн 1.3-т заасан агаарын бохирдлын томоохон суурин эх үүсвэрийг эрх бүхий байгууллагад мэдэгдээд ашиглана.”

4 дүгээр зүйл. Агаарын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.14 дэх заалтын “ашиглах зөвшөөрөл эзэмшигч” гэснийг “ашиглагч” гэж, 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсгийн “зөвшөөрөлд” гэснийг “мэдэгдлийн маягтад” гэж, 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсгийн “байгууллагаар хянуулан зөвшөөрөл авна” гэснийг “хянаана” гэж, 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсгийн “жагсаалт болон энэ хуулийн 25.5-д заасан мэргэжлийн байгууллагын эрх олгоход тавигдах шаардлагыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тэдгээрийг импортлох, худалдах, ашиглах тусгай зөвшөөрөл олгох журмыг Засгийн газар” гэснийг “жагсаалт, Зөвшөөрлийн тухай хуулийн 8.3 дугаар зүйлийн 1.1, 1.2-т заасан мэдэгдлээр эрхлэх үйл ажиллагааны маягтыг байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн” гэж, мөн зүйлийн 25.2 дахь хэсгийн “тогтоож, импортлох, худалдах, ашиглах зөвшөөрөл олгоно” гэснийг “тогтооно” гэж, 25.4 дэх хэсгийн “энэ хуулийн 25.2-т заасан импортлох, худалдах, ашиглах зөвшөөрөл авсан” гэснийг “Зөвшөөрлийн тухай

хуулийн 8.3 дугаар зүйлийн 1.1-д заасан мэдэгдлээр эрхэлж байгаа, эсхүл байсан” гэж, 25.5 дахь хэсгийн “төрийн захиргааны төв байгууллагаас эрх олгосон мэргэжлийн байгууллага гүйцэтгэнэ” гэснийг “Зөвшөөрлийн тухай хуулийн 8.3 дугаар зүйлийн 2-т заасны дагуу мэдэгдлээр эрхэлнэ” гэж, 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсгийн “зөвшөөрөл олгоно” гэснийг “гүйцэтгүүлнэ” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл.Агаарын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 хэсгийг, 18 дугаар зүйлийн 18.4 дэх хэсгийг, 25 дугаар зүйлийн 25.6 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

6 дугаар зүйл.Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл 4

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨНИЙ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн, 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсгийн, 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсгийн, 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийн, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн “Зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл 5

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

АМЬТНЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Амьтны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2.5, 5.7.2 дахь заалтын, 7 дугаар зүйлийн 7.7 дахь хэсгийн, 25 дугаар зүйлийн 25.5 дахь хэсгийн, 29¹ дүгээр зүйлийн 29¹.1 дэх хэсгийн, 36 дугаар зүйлийн 36.1, 36.5 дахь хэсгийн “Зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж, 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсгийн “Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1.15-д заасан ховор”

гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 1.17-д заасан” гэж, 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсгийн “Засгийн газар” гэснийг “Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэж, 36.4 дэх хэсгийн “Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1.13-т заасан харь” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 1.18-д заасан” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл 6

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

АРХИВ, АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн, 26 дугаар зүйлийн 26.3.4 дэх заалтын, мөн зүйлийн 26.6 дахь хэсгийн “Зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 26.7 дахь хэсгийн “тусгай” гэснийг хассугай.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл 7

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

АУДИТЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Аудитын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийн “Зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Аудитын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсгийн “тусгай” гэснийг хассугай.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл 8

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Ашигт малтмалын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 хэсгийн “Зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл 9

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

БАЙГАЛИЙН УРГАМЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Байгалийн ургамлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн “заасны дагуу” гэсний дараа “байгаль орчны асуудал эрхэлсэн” гэж, 13 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн “1.16-д заасны дагуу” гэсний дараа “байгаль орчны асуудал эрхэлсэн” тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл.Байгалийн ургамлын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн, 7 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн, 10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн, 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн, 12 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсгийн, 13 дугаар зүйлийн 3, 5 дахь хэсгийн, 15 дугаар зүйлийн 2, 7 дахь хэсгийн “Зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж, 13 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “сум, дүүргийн” гэснийг “аймгийн” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Байгалийн ургамлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “ахуйн” гэснийг, 13 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “эмийн” гэснийг, 13 дугаар

зүйлийн 5 дахь хэсгийн “эм” гэснийг, 11 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “тусгай” гэснийг тус тус хассугай.

4 дүгээр зүйл.Байгалийн ургамлын тухай хуулийн 17 дугаар зүйлийг, 20 дугаар зүйлийг тус тус хүчингүй болсонд тооцугай.

5 дугаар зүйл.Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл 10

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн “Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1.7-д заасан тусгай” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 1.21-д заасан” гэж, мөн зүйлийн 12.2, 12.9 дэх хэсгийн “Зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсгийн “тусгай” гэснийг хассугай.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл 11

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн “Зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

**БАНК БУС САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 9 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 9.5, 9.6, 9.7 дахь хэсэг нэмсүгэй:

“9.5.Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуулийн 8.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан үйл ажиллагааг мэдэгдлээр эрхэлнэ.

9.6.Энэ зүйлийн 9.5-д заасан мэдэгдлийн маягтыг мөн хуулийн 3.1 дүгээр зүйлийн 4-т заасны дагуу эрх бүхий этгээд батална.

9.7.Энэ зүйлийн 9.5-д заасан мэдэгдлээр эрхлэх үйл ажиллагааг цахимаар явуулна.”

2 дугаар зүйл. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 9 зүйл гарчгийн “зөвшөөрөл” гэсний дараа “, мэдэгдэл” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн, 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийн, 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийн “Зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж, 9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсгийн, 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсгийн “хорооны зөвшөөрөлтэйгээр” гэснийг “хороонд мэдэгдснээр” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

**БАНКНЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Банкны тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсгийн “Зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж, 26 дугаар зүйлийн 26.3 дахь

хэсгийн “Монголбанкны зөвшөөрөлтэйгээр” гэснийг “Монголбанкинд мэдэгдснээр” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл 14

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

БАРИЛГЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Барилгын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.21 дэх заалтын, 20 дугаар зүйлийн 20.1, 20.3, 20.6, 20.8, 20.12, 20.13 дэх хэсгийн, 27 дугаар зүйлийн 27.7, 27.8 дахь хэсгийн, 28 дугаар зүйлийн 28.5 дахь хэсгийн “Зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл 15

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

БОЛОВСРОЛЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Боловсролын ерөнхий хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн, 17 дугаар зүйлийн 17.14 дэх хэсгийн, 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2, 19.4, дэх хэсгийн, 20 дугаар зүйлийн 20.1, 20.2, 20.3, 20.5 дахь хэсгийн, 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2 дахь хэсгийн, 28 дугаар зүйлийн 28.2.3 дахь заалтын “Зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

**ГААЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Гаалийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2, 70.4 дэх хэсгийн “Тусгай зөвшөөрөл” гэснийг “Зөвшөөрөл” гэж, 70.2, 70.6 дахь хэсгийн “Зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж, мөн зүйлийн 70.6 дахь хэсгийн “Тусгай зөвшөөрлийг” гэснийг “Зөвшөөрлийг” гэж, тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Гаалийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн гарчгийн, 70.1, 70.3, 70.4, 70.5 дахь хэсгийн “тусгай” гэснийг тус тус хассугай.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл 17

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

**ГАДААДЫН ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.8 дахь хэсгийн “Зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл 18

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

ГАЗРЫН ТОСНЫ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 хэсгийн, 5 дугаар зүйлийн 5.2.5 дахь заалтын, 7 дугаар зүйлийн 7.5 дахь хэсгийн, 8 дугаар зүйлийн 8.5 дахь хэсгийн, 9 дүгээр зүйлийн 9.4, 9.6 дахь хэсгийн “Зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл 19

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

ГАЗРЫН ХЭВЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Газрын хэвлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 6, 8, 9 дэх хэсгийн, 42 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсгийн “Зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж, мөн хэсгийн “Засгийн газар” гэснийг “Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэж, мөн зүйлийн 7 дахь хэсгийн “Засгийн газраас” гэснийг “Газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Газрын хэвлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 10 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл 20

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

ГАЛТ ЗЭВСГИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Галт зэвсгийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж, 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсгийн “зэвсгээ бүртгүүлж, 13 дугаар зүйлд заасан галт зэвсгийн гэрчилгээ авснаар” гэснийг “бүртгүүлснээр” гэж, 12 дугаар зүйлийн 12.4 дэх хэсгийн “бүртгэх, галт зэвсгийн гэрчилгээ олгох эсэх асуудлаар” гэснийг “бүртгэж” гэж, 17 дугаар зүйлийн 17.7 дахь хэсгийн “бүртгүүлж галт зэвсгийн гэрчилгээ авна” гэснийг “бүртгүүлнэ” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Галт зэвсгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийг хүчингүй болсонд тооцугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл 21

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

ГАМШГААС ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3, 7.7 дахь хэсгийн “Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 11.8-д” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 10.21-д” гэж, мөн зүйлийн 7.7 дахь хэсгийн “Зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2, 7.3, 7.7 дахь хэсгийн, 29 дүгээр зүйлийн 29.1.14 дэх заалтын, 37 дугаар зүйлийн 37.2.8 дахь заалтын “тусгай” гэснийг тус тус хассугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл 22

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

ГЕНЕТИК НӨӨЦИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Генетик нөөцийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийн “Генетик нөөц” гэсний өмнө “Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1.8-д заасан” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл.Генетик нөөцийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн, 8 дугаар зүйлийн 8.1.3 дахь заалтын, 15 дугаар зүйлийн 15.1, 15.3, 15.4, 15.5, 15.11 дахь хэсгийн “Зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж, 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсгийн “энэ хуулийн 17.2-т заасан журмын дагуу” гэж “Зөвшөөрлийн тухай хуульд заасан журмын дагуу байгаль орчны асуудал эрхэлсэн” гэж, 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийн “Тусгай зөвшөөрөл” гэснийг “Энэ хуулийн 17.1-д заасны дагуу зөвшөөрөл авсан эзэмшигч” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Генетик нөөцийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл 23

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Геодези, зураг зүйн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн “Зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл 24

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

ГЭРЭЭТ ХАРУУЛ ХАМГААЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Гэрээт харуул хамгаалалтын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн, 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн, 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсгийн “Зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж, 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн “Тусгай зөвшөөрөл” гэснийг “Зөвшөөрөл” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Гэрээт харуул хамгаалалтын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5 дахь заалтын, 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн, 7 дугаар зүйлийн гарчгийн, 21 дүгээр зүйлийн 21.3 дахь хэсгийн “тусгай” гэснийг тус тус хассугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл 25

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

ГЭРИЙН ТЭЖЭЭВЭР АМЬТНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн 21 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 21.4, 21.5 дахь хэсэг нэмсүгэй:

“21.4.Зөвшөөрлийн тухай хуулийн 8.3 дугаар зүйлийн 8.1-д заасан мэдэгдлээр эрхлэх эзэнгүй амьтан түр байрлуулан асрамжлах үйл ажиллагааны маягтыг мал, амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.

21.5.Энэ хуулийн 21.4-т заасан мэдэгдлээр эрхлэх үйл ажиллагааг цахимаар явуулна.”

2 дугаар зүйл. Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсгийн “энэ хуульд заасны дагуу зөвшөөрөл авсан” гэснийг “эрх бүхий этгээдээс баталсан маягтын дагуу хариу хүлээн авсан” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

**ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.2 дахь заалтын “Зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

**ЗАР СУРТАЛЧИЛГААНЫ ТУХАЙ
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Зар сурталчилгааны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2 дахь заалтын “Зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Зээлийн мэдээллийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2, 23.7 дахь хэсгийн, 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсгийн, 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсгийн “Зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл 29

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

МАНСУУРУУЛАХ ЭМ, СЭТГЭЦЭД НӨЛӨӨТ БОДИСЫН ЭРГЭЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3, 8.6 дахь хэсгийн “Зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл 30

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ХИЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Монгол Улсын хилийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.11 дэх хэсгийн “Зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл 31

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

МУЗЕЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Музейн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3, 5.6, 5.9, дахь хэсгийн “Зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл 32

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

ӨМГӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Өмгөөллийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “энэ хууль” гэсний өмнө “Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хууль,” гэж, 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн “Өмгөөллийн үйл ажиллагаа” гэсний өмнө “Зөвшөөрөл, мэдэгдлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 10.18-д заасан” гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл 33

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

ОЮУНЫ ӨМЧИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Оюуны өмчийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсгийн “Зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Оюуны өмчийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.3 дахь заалтын, 16 дугаар зүйлийн 16.2, 16.3 дахь хэсгийн, 24 дүгээр зүйлийн 24.2.6 дахь заалтын “тусгай” гэснийг тус тус хассугай.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл 34

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

ӨРГӨН НЭВТРҮҮЛГИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн, 7 дугаар зүйлийн 7.5 дахь хэсгийн, 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийн, 10 дугаар зүйлийн 10.1, 10.6 дахь хэсгийн, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийн, 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсгийн, 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийн, 16 дугаар зүйлийн 16.1, 16.2 дахь хэсгийн “Зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл 35

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

РАДИО ДОЛГИОНЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Радио долгионы тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсгийн, 11 дүгээр зүйлийн 11.1, 11.2 дахь хэсгийн, 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсгийн, 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсгийн “Зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл 36

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.12 дахь хэсгийн, 38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсгийн, 52 дугаар зүйлийн 52.13 дахь хэсгийн “Зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл 37

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

СТАНДАРТЧИЛАЛ, ТЕХНИКИЙН ЗОХИЦУУЛАЛТ, ТОХИРЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“9.5.Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.5, 1.16, 1.17, 1.18, 1.24, 1.25, 1.29 дэх заалт, 7 дахь хэсгийн 7.2, 7.4, 7.6 дахь заалтад заасан тусгай зөвшөөрлийн болон 8.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.3, 1.9, 1.11, 1.17, 1.18,

1.19, 1.21 дэх заалт, 7 дахь хэсгийн 7.1 дэх 10 дугаар зүйлийн 10.16 дахь заалтад заасан энгийн зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэх үйл ажиллагаанд холбогдох техникийн зохицуулалтыг мөрдөнө.”

2 дугаар зүйл.Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6 дахь хэсгийн “Зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл 38

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

ТАМХИНЫ ХЯНАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Тамхины хяналтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.6, 7.12 дахь хэсгийн “Зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл 39

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

ТАТВАРЫН МЭРГЭШСЭН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн, 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсгийн, 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсгийн “Зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж, 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсгийн “Тусгай зөвшөөрөл” гэснийг “Зөвшөөрөл” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Татварын мэргэшсэн зөвлөх үйлчилгээний тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалтын, 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсгийн, 11 дүгээр зүйлийн 11.1.5 дахь заалтын, 12 дугаар зүйлийн гарчгийн, мөн зүйлийн 12.2 дахь

хэсгийн, 13 дугаар зүйлийн гарчгийн, 13.1, 13.3 дахь хэсгийн “тусгай” гэснийг тус тус хассугай.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл 40

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Төмөр замын тээврийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, 14.3 дахь хэсгийн “Зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл 41

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсгийн “Зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрөл, мэдэгдлийн” гэж, 6 дугаар зүйлийн гарчгийн, 16 дугаар зүйлийн 16.4 дэх хэсгийн, 22 дугаар зүйлийн гарчгийн, 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсгийн, 26 дугаар зүйлийн 26.1 дэх хэсгийн, 27 дугаар зүйлийн 27.3, 27.4 дэх хэсгийн, 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсгийн, 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсгийн, 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсгийн, 35 дугаар зүйлийн 35.2, 35.3 дахь хэсгийн, 36 дугаар зүйлийн 36.4, 36.6 дахь хэсгийн, 37 дугаар зүйлийн 37.5 дахь хэсгийн, 41 дүгээр зүйлийн 41.1, 41.5 дахь хэсгийн, 42 дугаар зүйлийн гарчгийн, 42.1 дэх хэсгийн, 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийн “Тусгай зөвшөөрөл” гэснийг “Зөвшөөрөл” гэж, 23, 24, 35 дугаар зүйлийн гарчгийн, 39 дүгээр зүйлийн гарчгийн, 39.1 дэх хэсгийн “Тусгай зөвшөөрлийн” гэснийг “Зөвшөөрлийн” гэж, 36 дугаар зүйлийн гарчгийн “Тусгай зөвшөөрлөөр” гэснийг

“Зөвшөөрлөөр” гэж, 37 дугаар зүйлийн гарчгийн “Тусгай зөвшөөрлийг” гэснийг “Зөвшөөрлийг” гэж тус тус өөрчилсүгэй.

